



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/361

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт хийх, хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрүүдийг сурталчлах ажлын зардалд зориулж 5000000 /таван сая/ төгрөгийг Захиалагчийн хяналтын зардлаас зарцуулсугай.

2. Дээрх зардлыг тухай бүр Захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д даалгасугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР